



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/12/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Х.Билэгбаяр Утас: 94009818 Цахим хаяг: Bilegbayarkh@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	4
3.1 Ерөнхий зүйл	4
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	4
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	4
3.4 Материаллаг байдал	5
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	5
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	6
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	7
3.8 Аудитын гол асуудал	7
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	8
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	8
4. Аудитын илрүүлэлт	9
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар





**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13, Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.24 № 44

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тайшир сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Тайшир сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүйгээр төсвийн хөрөнгөөр 5.3 сая төгрөгийн, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийг зөрчиж 14.4 сая төгрөгийн, амралт цалин давхардуулан 0.4 сая төгрөг илүү олгож тус тус гүйлгээ хийсэн. И баримт, татварын тодорхойлолтыг 14.9 сая төгрөгөөр илүү, дутуу тооцоолсон, 0.4 сая төгрөгийн тээвэр шатахууны тооцоог бодоогүй, шилэн дансны цахим сайтад мэдээллийг бүрэн байршуулаагүй зэрэг нийт 35.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь: Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>150,752,419.16</u>	<u>149,602,519.16</u>
33	АВЛАГА	-	3,500,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		
335	Бусад авлага	-	3,500,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	3,500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	150,752,419.16	146,102,519.16
354	Хангамжийн материал	19,147,419.16	14,497,519.16
35410	Бичиг хэргийн материал	815,139.00	815,139.00
35420	Аж ахуйн материал	18,332,280.16	13,682,380.16
35600	Мал амьтад	131,605,000.00	131,605,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>992,443,775.48</u>	<u>1,181,887,630.76</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	992,443,775.48	1,181,887,630.76
391	Газар		
392	Биет хөрөнгө	972,984,809.01	1,125,102,264.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	984,895,835.25	1,068,395,835.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	(312,834,631.01)	(381,938,169.96)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	58,963,160.00	58,963,160.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(23,129,857.78)	(33,274,854.59)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	149,228,625.60	119,732,255.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(80,140,965.97)	(60,916,064.33)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	48,242,256.77	40,022,496.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,967,250.65)	(18,488,387.16)
39209	Зам, гүүрийн байгууламж	323,685,380.00	333,685,380.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(206,773,076.58)	(210,879,439.26)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	9,720,000.00	9,720,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	65,963,320.01	233,782,500.01
39215	Хуримтлагдсан элэгдэл	(23,646,016.63)	(34,480,477.49)
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном	778,030.00	778,030.00
393	Биет бус хөрөнгө	19,458,966.47	56,785,366.52
39301	Програм хангамж	2,970,000.00	1,540,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,863,833.53)	(760,833.48)
39303	Бусад биет бус хөрөнгө	18,352,800.00	56,006,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,143,196,194.64</u>	<u>1,331,490,149.92</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,143,196,194.64</u>	<u>1,331,490,149.92</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,143,196,194.64	1,331,490,149.92
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	516,642,580.53	517,078,580.53
51101	Өмч: - төрийн	516,642,580.53	517,078,580.53
51102	- хувийн		
512	Хуримтлагдсан үр дүн	354,967,727.27	542,825,682.55
51210	Өмнөх үеийн үр дүн	354,967,727.27	354,967,727.27
51220	Тайлант үеийн үр дүн	-	187,857,955.28
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	271,585,886.84	271,585,886.84
51600	Нөөцийн сан		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,143,196,194.64</u>	<u>1,331,490,149.92</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	598,957,519.04	666,169,215.00
12.00	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	192,641,399.04	264,518,130.00
120.00	Нийтлэг татварын бус орлого	192,641,399.04	264,518,130.00
120,004.00	Төсөв байгууллагын өөрийн орлого	192,641,399.04	264,518,130.00
1,200,042.00	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	520,000.00	550,000.00
1,200,045.00	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	192,121,347.04	263,968,130.00
13.00	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	406,316,120.00	401,651,085.00
1,311.00	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,885,620.00	81,470,385.00
131,104.00	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,205,620.00	77,312,385.00
131,105.00	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,680,000.00	4,158,000.00
1,320.00	Орон нутгийн төсвөөс санхүүжих	390,430,500.00	320,180,700.00
132,001.00	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	390,430,500.00	320,180,700.00
2.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	485,007,781.43	478,311,259.72
21.00	УРСГАЛ ЗАРДАЛ	480,007,781.43	478,311,259.72
210.00	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	421,331,932.11	472,486,032.34
2,101.00	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	195,029,126.00	193,614,998.00
210,101.00	Үндсэн цалин	138,185,265.00	143,791,125.00
210,102.00	Нэмэгдэл	45,684,201.00	41,778,644.00
210,104.00	Урамшуулал	2,800,000.00	3,046,400.00
210,105.00	Гэрээт ажлын хөлс	8,359,660.00	4,998,829.00
2,102.00	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,118,950.68	24,479,558.82
210,201.00	Тэтгэврийн даатгал	22,054,415.04	17,198,548.18
210,202.00	Тэтгэмжийн даатгал	535,004.51	1,911,591.26
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	428,003.61	1,529,273.13
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	100,139.57	349,104.07
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	1,001,387.95	3,491,042.18
2,103.00	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,865,625.00	37,336,917.80
210,301.00	Гэрэл, цахилгаан	3,299,680.00	2,970,097.80
210,302.00	Түлш, халаалт	31,545,745.00	34,354,320.00
210,303.00	Цэвэр, бохир ус	20,200.00	12,500.00
2,104.00	Хангамж, бараа материалын зардал	23,670,080.96	20,950,085.00
210,401.00	Бичиг хэрэг	2,423,150.00	2,053,250.00
210,402.00	Тээвэр, шатахуун	15,758,320.00	15,042,985.00
210,403.00	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,786,961.00	2,562,650.00

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210,404.00	Ном, хэвлэл	15,000.00	33,300.00
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,971,400.00	1,257,900.00
2,105.00	Нормативт зардал	390,000.00	685,000.00
210,503.00	Нормын хувцас, зөөлөн эдлэл	390,000.00	685,000.00
2,106.00	Эд хогшил, урсгал засварын зардал	6,381,500.00	18,091,090.00
210,604.00	Урсгал засвар	6,381,500.00	18,091,090.00
2,107.00	Томилолт, зочны зардал	2,776,000.00	990,000.00
210,702.00	Дотоод албан томилолт	2,776,000.00	990,000.00
2,108.00	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,772,308.00	613,508.00
210,803.00	Даатгалын үйлчилгээ	180,000.00	180,000.00
210,805.00	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	11,000.00
210,806.00	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	320,000.00	340,000.00
210,807.00	Газрын төлбөр	-	82,508.00
2,109.00	Бараа үйлчилгээний бусад зардал	110,328,341.47	175,724,874.72
210,901.00	Бараа үйлчилгээний бусад зардал	19,842,500.80	58,696,150.00
210,902.00	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	450,000.00	50,000.00
210,903.00	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	90,035,840.67	116,978,724.72
213.00	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,675,849.32	5,825,227.38
2,132.00	Бусад урсгал шилжүүлэг	1,902,600.00	530,000.00
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,902,600.00	530,000.00
2,134.00	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	56,773,249.32	5,295,227.38
213,403.00	Төвлөрүүлэх шилжүүлэг	56,773,249.32	5,295,227.38
3.00	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>113,949,737.61</u>	<u>187,857,955.28</u>
5.00	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>113,949,737.61</u>	<u>187,857,955.28</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	516,642,580.53	271,585,886.84	354,967,727.27	1,143,196,194.64
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	516,642,580.53	271,585,886.84	354,967,727.27	1,143,196,194.64
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	436,000.00	0.00	0.00	436,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	187,857,955.28	187,857,955.28
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	517,078,580.53	271,585,886.84	542,825,682.55	1,331,490,149.92

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<u>415,836,120.00</u>	<u>402,201,085.00</u>

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	(1)		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	520,000.00	550,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	520,000.00	550,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	520,000.00	550,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	520,000.00	550,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	415,316,120.00	401,651,085.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	24,885,620.00	81,470,385.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,205,620.00	77,312,385.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,680,000.00	4,158,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	390,430,500.00	320,180,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	390,430,500.00	320,180,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	392,846,120.00	327,926,085.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	392,846,120.00	327,926,085.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	334,170,270.68	318,600,857.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	195,029,126.00	193,614,998.00
210101	Үндсэн цалин	138,185,265.00	143,791,125.00
210102	Нэмэгдэл	45,684,201.00	41,778,644.00
210104	Урамшуулал	2,800,000.00	3,046,400.00
210105	Гэрээт ажлын хөлс	8,359,660.00	4,998,829.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,118,950.68	24,479,558.82
210201	Тэтгэврийн даатгал	22,054,415.04	17,198,548.18
210202	Тэтгэмжийн даатгал	535,004.51	1,911,591.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	428,003.61	1,529,273.13
210204	Ажилгүйдлийн даатгал	100,139.57	349,104.07
210205	Эрүүл мэндийн даатгал	1,001,387.95	3,491,042.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,095,625.00	37,336,917.80
210301	Гэрэл, цахилгаан	3,299,680.00	2,970,097.80
210302	Түлш, халаалт	30,775,745.00	34,354,320.00
210303	Цэвэр, бохир ус	20,200.00	12,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,079,831.00	20,759,685.00
210401	Бичиг хэрэг	2,493,150.00	2,053,250.00
210402	Тээвэр, шатахуун	15,758,320.00	15,042,985.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,786,961.00	2,562,650.00
210404	Ном, хэвлэл	15,000.00	33,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,966,400.00	1,067,500.00
2105	Нормативт зардал	738,430.00	300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	738,430.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,550,000.00	17,976,590.00
210604	Урсгал засвар	10,238,000.00	17,976,590.00
2107	Томилолт, зочны зардал	2,776,000.00	990,000.00
210702	Дотоод албан томилолт	2,776,000.00	990,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,772,308.00	613,508.00

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	180,000.00	180,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	11,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	320,000.00	340,000.00
210807	Газрын төлбөр	-	82,508.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,010,000.00	22,529,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,560,000.00	22,479,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	450,000.00	50,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,675,849.32	9,325,227.38
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,902,600.00	530,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,902,600.00	530,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	56,773,249.32	8,795,227.38
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	56,773,249.32	8,795,227.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	22,990,000.00	74,275,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,990,000.00	74,275,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	74,275,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	320,680,700.00	315,435,472.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	320,680,700.00	315,435,472.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	320,180,700.00	314,935,472.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	190,810,500.00	190,568,598.00
210101	Үндсэн цалин	162,324,500.00	143,791,125.00
210102	Нэмэгдэл	21,709,100.00	41,778,644.00
210105	Гэрээт ажлын хөлс	6,776,900.00	4,998,829.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,399,300.00	24,448,758.82
210201	Тэтгэврийн даатгал	17,531,900.00	17,167,748.18
210202	Тэтгэмжийн даатгал	1,966,800.00	1,911,591.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,573,500.00	1,529,273.13
210204	Ажилгүйдлийн даатгал	393,400.00	349,104.07
210205	Эрүүл мэндийн даатгал	3,933,700.00	3,491,042.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,584,400.00	37,336,917.80
210301	Гэрэл, цахилгаан	4,000,000.00	2,970,097.80
210302	Түлш, халаалт	34,354,400.00	34,354,320.00
210303	Цэвэр, бохир ус	230,000.00	12,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,902,800.00	20,014,500.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	1,963,250.00
210402	Тээвэр, шатахуун	14,452,800.00	14,452,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,100,000.00	2,557,650.00
210404	Ном, хэвлэл	150,000.00	33,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	1,007,500.00

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	300,000.00	300,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,000,000.00	17,976,590.00
210604	Урсгал засвар	18,000,000.00	17,976,590.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	990,000.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	990,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	933,700.00	613,508.00
210803	Даатгалын үйлчилгээ	180,000.00	180,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	11,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	340,000.00	340,000.00
210807	Газрын төлбөр	133,600.00	82,508.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,250,000.00	22,686,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,200,000.00	22,636,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	50,000.00	50,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	500,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	320,680,700.00	315,435,472.62
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	320,680,700.00	315,435,472.62
132001	Орон нутгийн төсвөөс	20,680,700.00	315,435,472.62

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	77,970,385.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	77,970,385.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	77,940,385.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,046,400.00
210104	Урамшуулал	3,046,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,800.00
210201	Тэтгэврийн даатгал	30,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	745,185.00
210401	Бичиг хэрэг	90,000.00
210402	Тээвэр, шатахуун	590,185.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,118,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,118,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	77,970,385.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	77,970,385.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	73,812,385.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,158,000.00
--------	--	--------------

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Билэгбаяр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17 -ны өдрийн 3/24 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг даргын тамгын газар нь "Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрийн албаны стандартыг хангах, төр засгийн бодлого шийдвэрийг сурталчлан хэрэгжүүлэх, засаг даргыг цаг үе олон мэргэжлийн зөвлөмжөөр хангах зорилготой" байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 390.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 6.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлын нийт зардал 478.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.6 сая төгрөг, 80 хувь буюу 7.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлогдож байна.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16 хувиар буюу 188.3 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 146.1 сая төгрөг болж 4.6 сая төгрөгөөр өссөн нь хандив тусламжаар ирсэн бараа материалтай холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 32.1 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 32.3 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, 3.3 сая төгрөгийн бараа материал акталж, үйл ажиллагаандаа 65.7 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 146.1 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,922.6 сая төгрөг болж 259.8 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 74.3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 232.1 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 25.6 сая төгрөгийн хөрөнгийг данснаас акталж, 21.0 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэнтэй холбоотой байна. Тайлант оны эцэст 1,922.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Үндсэн хөрөнгө данс үнэ төлбөргүйгээр хүлээн авсан хөрөнгө нэмэгдсэн нь үлдэх өртгийг нэмэгдүүлэх шалтгаан болсон байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,331.4 сая төгрөг болж 188.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 543.0 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 296.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслийг 320.7 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс 24.7 сая төгрөгөөр өссөн нь урсгал засвар, засаг даргын нөөц хөрөнгийн зардалд тодотгол хийсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 320.7 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 320.7 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 315.4 сая төгрөгийг зарцуулж 5.3 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 315.4 сая төгрөг буюу 98 хувьтай байгаа нь 5.3 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 81.5 сая төгрөгийн орлого хүлээн авсан ба 81.5 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, худалдан авалтын И баримтыг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилт, худалдан авалтын И баримтыг хяналаа.

Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг даргын тамгын газар нь 2021 онд нийт 320.7 сая төгрөгийн 146 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим системд ил тод байршуулахаас 305.7 сая төгрөгийн 145 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна.

Горим сорил хэрэгжүүлсний үр дүнд шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн бөгөөд аудитаар мэдээлээгүй байгаа 1 төрлийн 15.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт

Санхүүгийн тайлангийн аудитаар тендерт шалгараагүй иргэн аж ахуйн нэгж байгууллагаас 14.5 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна" гэсэн заалттай нийцээгүй байна.

3.9.3 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 2.6 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 37.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг биелүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бараа материалын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулах, авлагын барагдуулалт, төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 97.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 61.7 сая төгрөгийг залруулан, 0.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 35.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн үр дүнгийн тайланг 61.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

- Амралтын цалинг давхардуулан 1 ажилтанд 0.4 сая төгрөгийн цалин илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно" гэсэн заалттай нийцэхгүй нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

- Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлалгүйгээр 5.3 сая төгрөгийг баяр ёслол тэмдэглэлт арга хэмжээнд зарцуулсан нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.6-т "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийг зөрчиж 14.5 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т "Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Мод услах болон мотор асаахад зарцуулсан 0.4 сая төгрөгийн шатахууны тооцоог бодоогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- И баримтгүй 2.6 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байгаа нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын

дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

- Татварын тодорхойлолтоор 12.3 сая төгрөгийн 13 нэр төрлийн татвар зөрүүтэй, газрын төлбөрийн үлдэгдэл 39.3 мянган төгрөг нийт 12,361.5 мянган төгрөгийн өглөг, авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.
- Батлагдсан төсвийг 10 хувиас доошгүй хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1.-т "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүллээ.

4.4 Зөвлөмж

1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1 төрлийн худалдан авалтыг мэдээлээгүй зөрчил илэрлээ.

3.3 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" гэсэн заалтыг мөрдөх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайшир сумын ЗДТГ	9	97.2	1	61.7	1	0.4	6	35.1	1	0.0